“Суралцахад ээлтэй, хүртээмжтэй сургууль” төслийн хүрээнд гарын авлагыг цахим хэлбэрт шилжүүлэх үйлчилгээ үзүүлэх ажлын даалгавар

1. Үндэслэл

Монгол Улсад хүүхдийн эрхийг хамгаалах, хүүхдийн сайн сайхан байдлыг хангах нь үндэсний хэмжээнд тэргүүлэх зорилтуудын нэг юм. 2024 оны 01 дүгээр сарын 17-ны өдөр батлагдаж, 09 дүгээр сарын 01-ний өдрөөс мөрдөж эхэлсэн Хүүхэд хамгааллын тухай хууль (шинэчилсэн найруулга)-ийн зорилго нь хүүхэд хамгаалллын үндэсний тогтолцоог бий болгох, хүүхэд хамгаалалд оролцогч талуудын эрх, үүргийг тодорхойлох, хүүхдийг эрсдэлт нөхцөлд өртөхөөс урьдчилан сэргийлэх, хүүхдэд шаардлагатай тусламж, үйлчилгээг үзүүлэх замаар хүүхдийн аюулгүй байдал, хамгаалуулах эрх, сайн сайхан байдлыг хангахад оршино.

Хүүхдийг Ивээх Сан (ХИС) нь Монгол Улсад хүүхдийн эрхийг хамгаалах үйлсэд сүүлийн 32 жилийн турш тэргүүлэх үүрэг гүйцэтгэж ирсэн байгууллагуудын нэг билээ. Бид хүүхэд хамгааллын үндэсний тогтолцоог хөгжүүлэх, нийгмийн ажилтнуудын чадавхыг бэхжүүлэх, хүүхдийн эсрэг хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, эцэг эхийн хараа хяналтгүй хүүхдүүдийг дэмжих, олон нийтэд түшиглэсэн хүүхэд хамгааллын үйлчилгээг бий болгох зэргээр төрийн байгууллага, иргэний нийгэм, олон нийттэй хамтран ажилласан арвин туршлагатай.

ХИС-ийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг www.savethechildren.mn цахим хуудаснаас авна уу.

2. Зөвлөх багийн ажлын зорилго

Монгол Улсад хүүхэд хамгааллын эрх зүйн орчин боловсронгуй болж, боловсролын байгууллагын хүүхэд хамгааллын чиг үүрэг, хариуцлага улам тодорхой болж байна. Гэсэн хэдий ч хүүхэд хамгааллын үйлчилгээг сургуулийн түвшинд жигд, чанартай хэрэгжүүлэх практик аргачлалын хэрэгцээ байсаар байна.

ХИС нь хүүхэд хамгааллын тогтолцоог бэхжүүлэх чиглэлээр төрийн болон орон нутгийн байгууллагууд, сургуулиудтай хамтран ажиллаж, “Ерөнхий боловсролын сургуулийн хүүхэд хамгааллын үйлчилгээний үлгэрчилсэн загвар” (цаашид “Үлгэрчилсэн загвар” гэх)-ыг боловсруулсан билээ. Энэхүү загвар нь (товч танилцуулгыг энэ линкнээс авна уу) сургуулийн удирдлага, багш, нийгмийн ажилтан, дотуур байрны ажилтан болон бусад оролцогчид өдөр тутмын ажилдаа хэрэглэх арга зүй, чиглэлийг нэгтгэсэн гарын авлага юм.

Боловсролын сайд болон Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын хамтарсан тушаалаар “Ерөнхий боловсролын сургуулийн хүүхэд хамгааллын үйлчилгээний үлгэрчилсэн загвар”-ыг үндэсний хэмжээнд түгээн дэлгэрүүлэх, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулахыг холбогдох төрийн байгууллагуудад үүрэг болгосон. Тушаалын хүрээнд ерөнхий боловсролын сургууль, дотуур байрны багш, ажилтнуудад сургалт зохион байгуулах, мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлэх, хэрэгжилтэд хяналт тавихаар шийдвэрлэсэн болно.

Тус үлгэрчилсэн загвар нь ерөнхий боловсролын сургуульд НҮБ-ын Хүүхдийн эрхийн тухай конвенц, түүний 1-р ерөнхий зөвлөмж, Монгол Улсын Хүүхдийн эрхийн тухай хууль, Хүүхэд хамгааллын тухай хууль, Боловсролын ерөнхий хууль, Сургуулийн өмнөх болон ЕБС-ийн багш, ажилтны мэргэжлийн ёс зүйн дүрэмд үндэслэн боловсруулагдсан бөгөөд ЕБС-уудад хүүхэд хамгааллын үйлчилгээг стандартчилах, урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх, хамгаалах, холбон зуучлах, хариу үйлчилгээ үзүүлэх тогтолцоог бүрдүүлэхэд чиглэсэн арга зүйн баримт бичиг юм.

Гол агуулга

Үлгэрчилсэн загвар нь ерөнхий боловсролын сургууль, дотуур байрны орчинд хүүхэд хамгааллын тогтолцоог бэхжүүлэх, удирдлага, багш, ажилтан, эцэг эх, сурагчдын үүрэг, оролцоог тодорхойлох, хүүхдийн эсрэг хүчирхийлэл, эрсдэлийг таних, үнэлэх, мэдээлэх, бүртгэх, холбон зуучлах, хариу арга хэмжээ авах үйл ажиллагааг зохицуулахад чиглэнэ. Мөн кейс менежмент, салбар дундын хамтын ажиллагаа, хүүхэд хамгааллын бодлого, журам, ёс зүйн хэм хэмжээ, сургуулийн орчны эрсдэлийн үнэлгээ, аюулгүй орчны менежментийг хамарч, багш, ажилтан, эцэг эх, сурагчдад өдөр тутмын үйл ажиллагаандаа ашиглах практик зөвлөмж, арга хэрэгслээр хангана.

Онцлог давуу тал

Энэхүү бичиг баримтын гол давуу тал нь хүүхэд хамгааллын хууль тогтоомжийг сургуулийн түвшинд хэрэгжүүлэх практик аргачлалаар хангаж, хүүхэд хамгааллын үйлчилгээний үе шат, хариу арга хэмжээг нэг мөр болгосонд оршино. Түүнчлэн боловсрол, нийгмийн хамгаалал, хүүхэд хамгааллын байгууллагуудын хамтын ажиллагааг бэхжүүлж, хүүхэд, эцэг эх, багш, сургуулийн удирдлагын оролцоог уялдуулахын зэрэгцээ хот, хөдөө, өмчийн хэлбэрээс үл хамааран ерөнхий боловсролын бүх сургуульд уян хатан хэрэгжүүлэх боломжтой юм.

Хүрэх үр дүн

Үлгэрчилсэн загварыг үе шаттайгаар нэвтрүүлснээр сургуулийн орчин дахь хүүхдийн аюулгүй байдал, хамгаалалт сайжирч, хүүхдийн эсрэг хүчирхийлэл, дээрэлхэлт, үл хайхрах байдлыг эрт илрүүлэх, урьдчилан сэргийлэх боломж нэмэгдэнэ. Мөн хүүхэд хамгааллын үйлчилгээний чанар, хүртээмж дээшилж, багш, ажилтан, эцэг эхийн мэдлэг, ур чадвар бэхжин, боловсролын салбарт хүүхдийн эрхийг хангах, хамгаалах тогтвортой тогтолцоог бүрдүүлэхэд хувь нэмэр оруулна.

3. Зөвлөх Ажлын цар хүрээ, үүрэг даалгавар

Зөвлөх баг нь “Ерөнхий боловсролын сургуулийн хүүхэд хамгааллын үйлчилгээний үлгэрчилсэн загвар”-ыг ерөнхий боловсролын сургууль, дотуур байрны удирдлага, багш, нийгмийн ажилтан болон бусад ажилтнуудад хүртээмжтэй, ойлгомжтой хэлбэрээр хүргэх, өдөр тутмын үйл ажиллагаандаа ашиглах боломжийг нэмэгдүүлэх зорилгоор цахим сургалтын хэрэглэгдэхүүн, видео хичээл болон холбогдох арга зүйн материалыг боловсруулна. Энэхүү ажлыг холбогдох төрийн байгууллагуудтай хамтран хэрэгжүүлж, боловсруулсан цахим бүтээгдэхүүнийг үндэсний хэмжээнд ашиглах боломжтой болгоход анхаарна.

Зөвлөх баг дараах үндсэн ажлуудыг гүйцэтгэнэ. Үүнд:

3.1. Үлгэрчилсэн загварыг цахим хэлбэрт шилжүүлэх

- “Ерөнхий боловсролын сургуулийн хүүхэд хамгааллын үйлчилгээний үлгэрчилсэн загвар”-ын агуулга, бүтэц, арга зүйтэй танилцаж, цахим хэлбэрт шилжүүлэх ажлын төлөвлөгөө боловсруулах;
- Үлгэрчилсэн загварын үндсэн агуулга, заавар, зөвлөмж, арга хэрэгслүүдийг хэрэглэгчдэд ойлгомжтой, ашиглахад хялбар цахим хэлбэрт хөрвүүлэх;
- Цахим бүтээгдэхүүнийг холбогдох төрийн байгууллагуудын одоо ашиглаж буй цахим сургалтын платформ, мэдээллийн системтэй уялдуулах боломжийг судалж, тохирох техникийн шийдлийг боловсруулах;
- Боловсруулсан материалыг компьютер, гар утас болон бусад цахим төхөөрөмжөөс ашиглах боломжтой, хүртээмжтэй хэлбэрээр бэлтгэх.

3.2. Цахим сургалтын хичээл, видео контент боловсруулах

- Үлгэрчилсэн загварын үндсэн агуулгад тулгуурлан сургуулийн удирдлага, багш, нийгмийн ажилтан, дотуур байрны ажилтнуудад зориулсан цахим сургалтын хичээлүүдийн агуулга, бүтэц, зохиомжийг боловсруулах;
- Хүүхэд хамгааллын тогтолцоо, оролцогч талуудын үүрэг, эрсдэлийг илрүүлэх, мэдээлэх, хариу арга хэмжээ авах, холбон зуучлах зэрэг гол сэдвүүдийг хамарсан видео хичээл, сургалтын материал бэлтгэх;
- Хичээлийн агуулгыг практик жишээ, нөхцөл байдал, тайлбар, дүрслэл ашиглан ойлгомжтой, сонирхолтой хэлбэрээр боловсруулах;
- Шаардлагатай тохиолдолд сургалтын агуулгыг бататгах богино асуулт, даалгавар болон нэмэлт хэрэглэгдэхүүн бэлтгэх.

3.3. Цахим бүтээгдэхүүнийг танилцуулах, санал авах, эцэслэх

- Боловсруулсан цахим хичээл, видео контент болон бусад хэрэглэгдэхүүний эхний хувилбарыг Хүүхдийг Ивээх Сан болон холбогдох төрийн байгууллагуудад танилцуулах;
- Боловсролын ерөнхий газар, Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын ерөнхий газар болон холбогдох мэргэжилтнүүдээс санал, зөвлөмж авах;
- Ирүүлсэн санал, зөвлөмжийг тусган цахим сургалтын агуулга, техникийн шийдэл, дүрслэл болон хэрэглэгчийн хүртээмжийг сайжруулж, бүтээгдэхүүнийг эцэслэх;

- Эцэслэсэн цахим бүтээгдэхүүнийг холбогдох төрийн байгууллагуудын цахим сургалтын платформд байршуулахад шаардлагатай бэлтгэлийг хангаж, байршуулах ажлыг зохион байгуулах;
- Цахим бүтээгдэхүүнийг ашиглах хэрэглэгчийн товч заавар, гарын авлага боловсруулж, бүх материалыг Хүүхдийг Ивээх Санд хүлээлгэн өгөх.

Зөвлөх баг нь ажлын бүх үе шатанд Хүүхдийг Ивээх Сан болон холбогдох төрийн байгууллагуудтай нягт хамтран ажиллаж, боловсруулсан бүтээгдэхүүний агуулга, чанар, хүртээмжийг хангахын зэрэгцээ цаашид үндэсний хэмжээнд сургалт, арга зүйн дэмжлэг үзүүлэхэд тогтвортой ашиглах боломжийг бүрдүүлнэ.

4. Хүлээгдэж буй үр дүн

Зөвлөх баг нь захиалагч талд дараах бүтээгдэхүүнийг хүлээлгэн өгнө. Үүнд:

- “Ерөнхий боловсролын сургуулийн хүүхэд хамгааллын үйлчилгээний үлгэрчилсэн загвар”-ын дагуу боловсруулсан цахим хичээлүүд;
- “Ерөнхий боловсролын сургуулийн хүүхэд хамгааллын үйлчилгээний үлгэрчилсэн загвар”-ын агуулгыг эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч болон хүүхдүүдэд танилцуулах мэдээллийн постер бэлтгэх;
- “Ерөнхий боловсролын сургуулийн хүүхэд хамгааллын үйлчилгээний үлгэрчилсэн загвар”-ын дагуу бэлтгэсэн цахим хичээлүүдийг холбогдох төрийн байгууллагуудын цахим платформ-д байршуулах;
- “Ерөнхий боловсролын сургуулийн хүүхэд хамгааллын үйлчилгээний үлгэрчилсэн загвар” болон цахим бүтээгдэхүүнийг ашиглах хэрэглэгчийн гарын авлага боловсруулах;
- Зөвлөх үйлчилгээний тайлан /англи-монгол хэлээр/ -г захиалагч талд тус тус хүлээлгэн өгнө

5. Хамрах хүрээ

Монгол Улсын боловсролын салбарын хүүхэд хамгааллын үйл ажиллагааг дэмжих хүрээнд дараах байгууллага, нэгжийг хамарна. Үүнд:

- Ерөнхий боловсролын сургуулиуд;
- Ерөнхий боловсролын сургуулийн дотуур байрууд.

Зөвлөх үйлчилгээний хүрээнд ерөнхий боловсролын сургууль, дотуур байрны хүүхэд хамгааллын үйл ажиллагаа, үйлчилгээний зохион байгуулалт, мэдээлэл бүртгэл, тайлагналын хэрэгцээ шаардлагыг харгалзан боловсруулалт хийнэ. Мөн сургуулийн орчин дахь хүүхэд хамгааллын үйл ажиллагааг нэгдсэн байдлаар дэмжих, мэдээллийн хүртээмж, ашиглалтыг сайжруулахад чиглэнэ.

6. Ажил гүйцэтгэх хугацаа

Зөвлөх үйлчилгээг гүйцэтгэгч нь гэрээт ажлыг 2026 оны 12 дугаар сарын 01-ны өдрөөс 2026 оны 12 дугаар сарын 28--ны өдрийг хүртэлх хугацаанд гүйцэтгэнэ.

№	Үйл ажиллагаа	Хугацаа	Тайлбар
1	“Ерөнхий боловсролын сургуулийн хүүхэд хамгааллын үйлчилгээний үлгэрчилсэн загвар”-тай танилцах, төлөвлөгөө гаргах	Ажлын 2 хоног	Боловсролын сайд, ГБХНХ-ын сайдын А/306, А/172 дугаар хамтарсан тушаал болон үлгэрчилсэн загвартай танилцах, цахим сургалтын бичлэг хийх болон бусад ажлын дэлгэрэнгүй төлөвлөгөөг боловсруулж батлуулсан байна.
2	Цахим сургалтын бичлэг хийх, мэдээллийн зураг хуудас (постер) эхний загварыг боловсруулах	Ажлын 5 хоног	Цахим сургалтын бичлэг болон эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч, хүүхдүүдэд зориулсан мэдээллийн постерын эхний хувилбарыг боловсруулсан байна.
3	Цахим сургалтын бичлэг болон мэдээллийн постерыг эцэслэх	Ажлын 3 хоног	Холбогдох яамд болон ХИС-ийн саналыг тусган цахим сургалтын бичлэг, мэдээллийн постерыг эцэслэсэн байна.
4	Эцэслэсэн бүтээгдэхүүнийг цахим платформд байршуулах	Ажлын 3 хоног	Бүтээгдэхүүнийг цахим платформд байршуулж, ЕБС-уудад танилцуулсан байна.

№	Үйл ажиллагаа	Хугацаа	Тайлбар
5	Бүх бүтээгдэхүүнийг захиалагч талд хүлээлгэн өгөх	Ажлын 2 хоног	Бүх бүтээгдэхүүнийг захиалагч тал хүлээн авсан байна.
6	Зөвлөх үйлчилгээний үр дүнгийн тайлан боловсруулах	Ажлын 2 хоног	Бүх хийгдсэн ажлын таланг англи-монгол хэлээр боловсруулж захиалагчид хүргүүлсэн байна.
7	Гэрээт ажлын гүйцэтгэлийг дүгнэх	Ажлын 1 хоног	ХИС гэрээт ажлыг дүгнэж санхүүжилтийг олгосон байна.

7. Зөвлөх багийн бүрэлдэхүүн, мэргэжилтэнүүдэд тавигдах шаардлага

Зөвлөх баг нь дараах дараахь мэргэжилтнээс бүрдэж болох бөгөөд гишүүн бүр өөрийн чиг үүргийн хүрээнд шаардлагатай мэдлэг, ур чадвар, мэргэжлийн туршлагатай байна. Үүнд:

1. Багийн ахлагч – Удирдлага, зохион байгуулалт, төрийн байгууллагын уялдаа холбооны мэргэжилтэн (1 хүн)

- Төрийн удирдлага, нийтийн удирдлага, боловсролын удирдлага, нийгмийн бодлого, олон улсын харилцаа болон холбогдох чиглэлээр магистр болон түүнээс дээш зэрэгтэй байх.
- Төрийн байгууллага, яам, агентлаг, орон нутгийн байгууллага болон олон улсын байгууллагатай хамтран ажилласан, салбар дундын уялдаа холбоог хангаж байсан туршлагатай байх.
- Төсөл, хөтөлбөр, зөвлөх үйлчилгээний баг удирдан зохион байгуулах, ажлын төлөвлөгөө боловсруулах, хэрэгжилтийг зохицуулах, үр дүнг нэгтгэх, тайлагнах туршлагатай байх.
- Бодлого, хууль эрх зүйн баримт бичиг, журам, зөвлөмж боловсруулах, холбогдох талуудын хэлэлцүүлэг, уулзалт зохион байгуулах чадвартай байх.
- Төрийн байгууллагуудын хэрэгцээ шаардлагыг тодорхойлох, санал зөвлөмжийг нэгтгэх, байгууллага хоорондын зөвшилцөл, хамтын ажиллагааг хангах чадвартай байх.
- Монгол, англи хэлээр мэргэжлийн болон албан баримт бичиг боловсруулах, харилцаа холбоо тогтоох өндөр ур чадвартай байх.

2. Мэдээллийн технологийн мэргэжилтэн (1 хүн)

- Мэдээллийн технологи, программ хангамж, мэдээллийн систем, компьютерын ухаан болон холбогдох чиглэлээр бакалавр болон түүнээс дээш боловсролын зэрэгтэй байх.
- Мэдээллийн сангийн бүтэц, өгөгдлийн ангилал, мэдээлэл боловсруулах, хадгалах, хамгаалах, системийн архитектур болон мэдээллийн системийн шийдэл боловсруулах чиглэлээр ажлын туршлагатай байх.
- Цахим платформ, мэдээллийн систем хөгжүүлэх, нэвтрүүлэх, сайжруулах чиглэлээр ажилласан туршлагатай байх.
- Хэрэглэгчийн хэрэгцээ шаардлагад нийцсэн системийн техникийн шийдэл боловсруулах, системийн найдвартай ажиллагаа, мэдээллийн аюулгүй байдлыг хангах мэдлэг, ур чадвартай байх.
- Төрийн болон байгууллагын мэдээллийн систем, өгөгдлийн сан хөгжүүлсэн туршлагатай бол давуу тал болно.

3. Хүүхэд хамгааллын чиглэлээр мэргэшсэн мэргэжилтэн (1 хүн)

- Хүүхэд хамгаалал, хүүхдийн эрх, нийгмийн ажил, сэтгэл судлал, боловсрол, нийгмийн хамгаалал болон холбогдох чиглэлээр бакалавр болон түүнээс дээш боловсролын зэрэгтэй байх.
- Хүүхэд хамгааллын хууль тогтоомж, бодлого, үндэсний тогтолцоо, үйлчилгээний стандарт, салбар дундын хамтын ажиллагааны талаар мэргэшсэн мэдлэгтэй байх.
- Хүүхэд хамгааллын үйлчилгээ, эрсдэлийн үнэлгээ, тохиолдлын менежмент, хүүхдийн эсрэг хүчирхийлэл, дарамт, дээрэлхэлтээс урьдчилан сэргийлэх чиглэлээр ажилласан туршлагатай байх.
- Хүүхэд хамгааллын чиглэлээр сургалтын модуль, гарын авлага, арга зүйн зөвлөмж, цахим сургалтын агуулга боловсруулах туршлагатай байх.
- Хүүхдийн эрхэд суурилсан, хүүхдийн аюулгүй байдал, нууцлал, хувийн мэдээллийн хамгааллыг хангасан арга зүй боловсруулах чадвартай байх.

4. Цахим сургалтын контент, хичээл боловсруулах мэргэжилтэн (1 хүн)

- Боловсрол, сургалтын технологи, сургалтын дизайн, цахим сургалт, мультимедиа болон холбогдох чиглэлээр бакалавр болон түүнээс дээш боловсролын зэрэгтэй байх.
- Цахим хичээл, видео хичээл, интерактив сургалтын материал, цахим ном, гарын авлага болон дижитал сургалтын контент боловсруулах чиглэлээр ажлын туршлагатай байх.
- Сургалтын хэрэгцээ, зорилтот бүлгийн онцлогт нийцүүлэн сургалтын агуулга, хичээлийн бүтэц, арга зүй, суралцахуйн үр дүн, үнэлгээний даалгавар боловсруулах чадвартай байх.
- Цахим сургалтын платформд байршуулахад тохиромжтой хэлбэрээр сургалтын материал бэлтгэх, мультимедиа болон интерактив технологи ашиглах мэдлэг, ур чадвартай байх.
- Хүүхэд, багш, эцэг эх, хүүхэд хамгааллын үйлчилгээний ажилтан зэрэг зорилтот бүлгүүдэд зориулсан сургалтын контент боловсруулж байсан туршлагатай бол давуу тал болно.
- Өмнө боловсруулж, хэрэгжүүлсэн цахим хичээл, сургалтын контентын жишээ, ажлын портфолиотой байх.

Сонгон шалгаруулалтад тавих нийтлэг шаардлага

Зөвлөх багийн бүх гишүүд дараах нийтлэг шаардлагыг хангасан байна:

1. Өөрийн хариуцах чиглэлээр мэргэжлийн мэдлэг, ур чадвар, холбогдох ажлын 3-аас доошгүй жилийн туршлагатай байх.
2. Багаар ажиллах, мэдээлэл солилцох, бусад мэргэжилтнүүдтэй уялдаа холбоотой ажиллах чадвартай байх.
3. Ажлын төлөвлөгөө, тайлан, судалгаа, зөвлөмж болон бусад шаардлагатай баримт бичиг боловсруулах чадвартай байх.
4. Хүүхдийн эрх, хүүхэд хамгааллын зарчим, мэдээллийн нууцлал, ёс зүйн шаардлагыг чанд мөрдөх.
5. Өмнө гүйцэтгэсэн ижил төстэй ажлын туршлагаа нотлох баримт, ажлын жишээ, портфолиогоор баталгаажуулах.

8. Бүрдүүлэх материал

Энэхүү зөвлөх үйлчилгээний сонгон шалгаруулалт оролцох сонирхсон Зөвлөх багууд дараах материалыг бэлтгэн ирүүлнэ. Үүнд:

1. Зөвлөх үйлчилгээг гүйцэтгэх сонирхлоо илэрхийлсэн захидал. Захидалд дараах мэдээллийг тусгана: гүйцэтгэх ажлын зорилго, цар хүрээний талаарх ойлголтоо тодорхой илэрхийлсэн байх; ажил гүйцэтгэх арга зүй болон хэрэгжүүлэх нарийвчилсан төлөвлөгөө;
2. Боловсрол, мэргэжил, холбогдох ажлын туршлагыг тусгасан намтар (CV)-ыг Монгол эсвэл Англи хэлээр ирүүлэх;
3. Өмнө гүйцэтгэсэн ижил төстэй ажлын жишээ материал (тухайлбал, цахим ном, гарын авлага, видео, зөвлөмж зэрэг)-ыг Монгол эсвэл Англи хэлээр ирүүлэх;
4. Зөвлөх үйлчилгээний хөлс болон холбогдох бусад зардлыг багтаасан үнийн саналыг Монгол эсвэл Англи хэлээр ирүүлэх.

Дээрх материалыг PDF файл болгон 2026 оны 11-р сарын 22-ны өдөр, 17.00 цагаас өмнө дараах имэйл хаягаар ирүүлнэ үү: mongolia.secretary@savethechildren.org. Шаардлага хангасан Зөвлөх багтай бид эргэн холбогдоно. Баярлалаа.

8. Тайлагналт, хяналт

Зөвлөх үйлчилгээний хугацаанд ХИС-ийн хүүхэд хамгааллын төслийн нэгжээс шаардлагатай мэргэжлийн болон арга зүйн дэмжлэг үзүүлнэ. Зөвлөх нь ажлын явц, гүйцэтгэл болон ур дүнгийн талаарх мэдээллийг ХИС-ийн төслийн зохицуулагчид тогтмол тайлагнана.

---o0o---